



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013-05-06 № 03170

Барьцааны мөнгийг төсөвт төвлөрүүлэх тухай

Боловсрол, шинжлэх ухааны сайдын төсвийн багцын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

БСШУ-ны (хуучин нэрээр) сайдын 2012 оны 162 дугаар тушаалаар баталсан БНХАУ-ын "Соёлын сар" арга хэмжээнд оролцох багийн бүрэлдэхүүн, төсвийг үндэслэн хэвлэлийн ажилтан Л.Зоригтод хэвлэл мэдээллийн барьцаанд тавиад буцааж төлөх нөхцөлтэй урьдчилгаа тооцоогоор олгосон 6.183.900 төгрөгийг өнөөг хүртэл яамны дансанд тушаагаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д " батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ыг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хэвлэл мэдээллийн барьцаанд тавиад буцааж тушаах ёстой 6.183.900 (Зургаан нэг зуун наян гурван мянга есөн зуун) төгрөгийг Л.Зоригтоор нөхөн төлүүлж Төрийн сан банкин дахь Үндэсний аудитын газрын Төсвийн орлогын 900000601 тоот дансанд 2013 оны 10 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх,
2. Актын биелэлтийг 2013 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг БШУЯ-ны СХОХ-ийн дарга Ц.Баярхүү, ерөнхий нягтлан бодогч Х.Ганцэцэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН

ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын


Ахлах аудитор  Ц.Гэрэл

УХА0122

ЗӨВШӨӨРСӨН:

Боловсрол, шинжлэх ухааны яамны

СХОХ-ийн дарга  Ц.Баярхүү

Ерөнхий нягтлан бодогч  Х.Ганцэцэг